МОНГОЛ УЛС
**АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР**
14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-0251,
E-mail: comcor@iaac.mn, http://iaac.mn

2021.02.24 № 05/1333
танай ____________-ны № ____________-т

ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГА Ц.МӨНХБАТ
ТАНАА

С. Хулан-д
Зохих журмын дагуу уялдаат, тайлагнах тосол боловсруулах
[signature] III/02

Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянасан тухай

Дундговь аймгийн “Дундговь-Ус” ОНӨҮГ-ын даргаар томилогдохоор нэр дэвшсэн Отгонбаярын Бархүүгийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6 дахь хэсэгт заасныг үндэслэн хянан үзэхэд ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал одоогоор тогтоогдоогүй болно.

Нэр дэвшигч О.Бархүү “Суварга-Онгиуд” ХХК-ийн захирлаар, “Мөнхдэлгэрэх ундарга” ХХК-ийн гүйцэтгэх захирлаар тус тус бүртгэлтэй байх тул “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай” хуулийн 19 дүгээр зүйлд заасан давхар ажил эрхлэхтэй холбогдсон хязгаарлалтыг хэрэгжүүлэх журмыг баримтлан ажиллах нь зүйтэй.

Нэр дэвшигч нь Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.3, Нийтийн албан нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3-т заасан хугацаанд хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг гаргаж, тухайн албан үүргийг гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөл байдалд дээрх хуулийн 8 дугаар зүйлд заасан мэдэгдэл, тайлбарыг тухай бүр гаргаж байх, мөн хуульд заасан хориглолт, хязгаарлалтыг хэрэгжүүлж ажиллахад анхаарна уу.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДҮН
ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА,
ЭРХЭЛСЭН КОМИССАР [signature] Х.ХАШБААТАР

УХА0422 5120829

C:DOCUMENTS\ALBANBICHIG A4

0001030